

1. Тогтсон үерийн ус татарсан газарт Ариутгал халдваргүйтгэлийн ажлын хэсгийнхэн 2018 оны 07 дугаар сарын 21-ээс эхлэн 8 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар үерт автсан 2,3, 12, 13 багуудын нийт 526 өрхийн 1,332,180 кв талбайд хөрсний ариутгал хийгдэж, 752 флакон жавелион ариутгалын бодис хэрэглэсэн. Ариутгалд ДУК машин 3, автомакс 9, Ховд аймгийн Зэвсэгт хүчний 123 дугаар ангиаас ирсэн 2 ДУК машин, ЗИЛ 131.Е450069, Зил 131.Е.450076 марктай. ХХАА-ийн машин ДУК Уаз марктай БӨТ36-69. ЭМГ-12, МХГ- 2, Цэргийн анги-6, ЗӨСТ-4, ХХАА-1 хүн тус тус ажиллаж байна.

2. Хоёр дугаар улиралд гарсан нярайн эндэгдэлийг хэлэлцсэн хурлын холбогдох материалыг бүрдүүлж ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд хүргүүлэв.

3. 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулж харьяа байгууллагуудад хүргүүлсэн.

#### Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 85

Амьд төрөлт - 85

Амьгүй төрөлт- 1

Дутуу төрөлт - 2

Нялхсын эндэгдэл- 0

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл- 0

Эхийн ноцтой хүндрэл- 0

Төрөлхийн гажиг- 1

Гэрийн төрөлт- 0

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 31 дүгээр долоо хоногт нийт 2635 хүн үйлчлүүлсний 24(0.9%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.4%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (112)-ийн дотор 12 буюу 10,7 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 3,3%-иар буурсан үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 266 дуудлагын 34 (12,7%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 1,9%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 31 дүгээр 7 хоногт аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд Томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 18(100%) удаа ирүүлсэн байна.